



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 6 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 233


Улаанбаатар
хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Авто замын тухай хуулийн 22.4, 23.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын чанартай А0202 дугаартай Мандалговь-Даланзадгад чиглэлийн 305.1 км авто замыг засварлах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад шаардагдах 3,412,250,000 (гурван тэрбум дөрвөн зуун арван хоёр сая хоёр зуун тавин мянга) төгрөгийг нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлэх арга хэмжээ авахыг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Д.Батбаатар), гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт даалгасугай.

2. Авто замын засварын ажлыг зохих журмын дагуу шуурхай гүйцэтгүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч, гүйцэтгэлийг хянаж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтарт даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Зам, тээврийн хөгжлийн сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Л.ХАЛТАР



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/190

Улаанбаатар хэд


Авто замын засварын ажлын тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны 233 дугаар тогтоол, Авто замын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.9, 10.2, 22 дугаар зүйлийн 22.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засгийн газрын 2022 оны 233 дугаар тогтоолын дагуу шийдвэрлэгдсэн хөрөнгөөр А0202 дугаартай Мандалговь-Даланзадгад чиглэлийн 305.1 км авто замд хийгдэх засварын ажлын төрөл, хэмжээ, зарцуулах хөрөнгийн жагсаалт"-ыг хавсралтаар баталсугай.


2.Баталсан жагсаалтын дагуу 3,412,250,000.0 (Гурван тэрбум дөрвөн зуун арван хоёр сая хоёр зуун тавин мянга) төгрөгөөр хийгдэх засварыг ажлыг тухайн чиглэлийн зам хариуцагч "Дундговь авто зам" ХХК, "Даш зам" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга С.Батболдод зөвшөөрсүгэй.

3.Авто замын засварын ажлыг шуурхай зохион байгуулж техник технологийн өдөр тутмын хяналт тавьж ажиллахыг "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ (Х.Пүрэвжаргал), засварын ажлыг төлөвлөсөн хугацаанд гүйцэтгүүлж хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажиллахыг Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Б.Оюундэлгэр), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (М.Энхболд)-т тус тус үүрэг болгосугай.



0200000000

Зам, тээврийн хөгжлийн сайдын
 2022 оны 16 дугаар сарын 16 өдрийн
 А/190 дугаар тушаалын хавсралт



А0202 дугаартай Мандалговь-Даланзадгад чиглэлийн 305.1 км авто замд хийгдэх засварын ажлын төрөл, хэмжээ, зарцуулах хөрөнгийн жагсаалт

№	Замын дугаар	Засвар хийгдэх замын чиглэл, хийгдэх ажлын төрөл, хэмжээ	Зарцуулах төсөвт өртөг	Гүйцэтгэх зам хариуцагч
1	А0202	Мандалговь-Даланзадгад чиглэлийн авто замын 85-105 км-т хучилтын нийт 12118 м2 нүхэн эвдрэлийг халуун асфальтбетоноор засварлах	3 003 797 448	"Дундговь авто" зам ХХК
		Мандалговь-Даланзадгад чиглэлийн авто замын 85-105 км-т хэсэгчилсэн нийт 5,048 км замын суурийг цементээр бэхжүүлэн 5 см асфальтбетон хучилт хийх		
2		Мандалговь-Даланзадгад чиглэлийн авто замын 180-260 км-т хучилтийн нийт 2900 м2 нүхэн эвдрэлийн суурийг цементээр бэхжүүлэн халуун асфальтбетоноор засварлах	408 452 552	"Даш зам" ХХК
		Дүн	3 412 250 000	